

I/2021

Тархаасан: 2021 оны 03 дугаар сарын 13




Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 23.0 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, түршилт тооцоогоор) 2021 оны 1 дүгээр сард 146.5 болж, өмнөх оны мөн үеэс 23.0 хувь, өмнөх сараас 1.3 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, түршилт тооцоогоор) 2021 оны 1 дүгээр сард 139.9 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 19.6 хувь, өмнөх сараас 4.2 хувиар тус тус өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 21.4 хувь (төмрийн хүдэр болон зэсийн баяжмал) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, түршилт тооцоогоор) 2021 оны 1 дүгээр сард 95.5 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурсан байна. Харин өмнөх сараас 2.9 хувиар өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурахад машин тоног төхөөрөмжийн бүлгийн үнэ 2.6 хувь, эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 19.2 хувь (нефть) буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 1. Гадаад худалдааны нөхцөлийн индекс¹ (2015=100), хувь



¹ Түршилт тооцоо

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Ангилал: Барааг тодорхойлох, кодлох үялдуулсан систем

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Мэдээ тархаах хуваарь: 2021 оны 04 дүгээр сарын 15



*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Г.Мөнх-Оргил
Утас : (976-51)-261561*

